



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.02.20

№

227

танай

-ны №

-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.АРИУНАА ТАНАА

Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт *4* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002031706



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/807/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

“ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн
Захирал: Д.Энхбаатар
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Аудитын менежер: Ж.Эрдэнэбилэг
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Аудитор: Д.Мэндбаяр
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК
Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	17
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	20
3.5.3 Нэмэлт төсөв	21
4. Аудитын тайлан	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. Аудитын илрүүлэлт	23
5.1 Зөвлөмж	23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ННДГ	Нийслэлийн нийгмийн даатгалын газар
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ЭМНДЕГ	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.02.20 № 227

танай _____-ны № _____-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА,
Н.АРИУНАА ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлж байгаа нөхцөл байдал аудит хийх шалгалтын явцад илрээгүй ба материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах, хууль ёсны эрхийг хамгаалах нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой, чанартай хүргэх хөтөлбөрийн хүрээнд 4 зорилт, 8 арга хэмжээ, 59 хөтөлбөрийг төлөвлөн 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,864,749,660.31</u>	<u>99,914,664,810.01</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,512,831,084.85	15,236,145,112.12
312	Банканд байгаа бэлэн мөнгө	16,512,831,084.85	15,236,145,112.12
3121	Төгрөг	16,512,831,084.85	15,236,145,112.12
31211	Төрийн сангийн харилцах	9,334,846.96	-
31213	Арилжааны банк дахь харилцах	16,503,496,237.89	15,231,809,012.12
31214	Бусад төсөл, нөөц харилцах	-	4,336,100.00
33	АВЛАГА	<u>130,313,636,280.96</u>	<u>84,639,850,524.39</u>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	25,354,871,673.31	35,254,988,593.40
33300	Татаас, санхүүжилтийн авлага	104,791,001,929.81	49,228,389,201.81
335	Бусад авлага	<u>167,762,677.84</u>	<u>156,472,729.18</u>
3351	Байгууллагаас авах авлага	167,762,677.84	156,472,729.18
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>38,282,294.50</u>	<u>38,669,173.50</u>
354	Хангамжийн материал	<u>38,282,294.50</u>	<u>38,669,173.50</u>
35410	Бичиг хэргийн материал	4,623,436.00	5,232,202.00
35420	Аж ахуйн материал	13,255,900.00	13,908,443.00
35440	Түлш, шатах тослох, сэлбэг материал	15,555,203.00	18,341,703.00
35470	Бусад хангамжийн материал	4,847,755.50	1,186,825.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,242,306,362.31</u>	<u>2,245,731,413.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>2,242,306,362.31</u>	<u>2,245,731,413.20</u>
392	Биет хөрөнгө	<u>2,215,117,682.31</u>	<u>2,218,542,733.20</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,259,969,856.00	2,259,969,856.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(141,550,178.84)	(180,768,985.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,864,000.00	9,864,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,466,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,552,692.68	120,215,135.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,355,544.86)	(32,776,927.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,312,010.00	131,312,010.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(73,675,152.67)	(86,806,356.04)
393	Биет бус хөрөнгө	<u>27,188,680.00</u>	<u>27,188,680.00</u>
39303	Бусад биет бус хөрөнгө	27,188,680.00	27,188,680.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>149,107,056,022.62</u>	<u>102,160,396,223.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,313,755,176.61</u>	<u>2,354,972,929.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>1,313,755,176.61</u>	<u>2,354,972,929.97</u>
413	Өглөг	<u>197,023,648.07</u>	<u>226,497,485.43</u>
41310	Ажилчидтай холбоотой өглөг	1,972,924.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	194,330,724.07	226,497,485.43
41360	Бусад өглөг	720,000.00	-
414	Урьдчилж орсон орлого	<u>1,116,731,528.54</u>	<u>2,128,475,444.54</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>147,793,300,846.01</u>	<u>99,805,423,293.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>629,969,700.64</u>	<u>629,969,700.64</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	300,550,663.51	300,550,663.51

51101	Өмч: - төрийн	300,550,663.51	300,550,663.51
512	Хуримтлагдсан үр дүн	147,163,331,145.37	99,175,453,592.60
51210	Өмнөх үеийн үр дүн	147,163,331,145.37	146,934,185,404.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	(47,758,731,812.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	329,419,037.13	329,419,037.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>149,107,056,022.62</u>	<u>102,160,396,223.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	379,205,460,607.11	493,592,206,895.54
11	ТАТВАРЫН ОРЛОГО	377,789,144,197.48	465,318,199,301.52
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	377,789,144,197.48	465,318,199,301.52
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	258,249,813,769.21	311,794,498,072.85
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	26,264,460,810.58	33,574,092,763.86
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	29,611,823,226.71	38,573,943,724.60
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	5,264,863,818.37	6,804,877,608.12
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58,398,182,572.61	74,570,787,132.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	218,388,931.63	407,045,207.02
120	Нийтлэг татварын бус орлого	218,388,931.63	407,045,207.02
120002	Хүүгийн орлого	18,803,461.39	2,075,273.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	158,394,493.58	98,662,431.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	144,998,493.58	98,256,431.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,532,000.00	406,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,864,000.00	-
120009	Бусад орлого	41,190,976.66	306,307,502.16
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,197,927,478.00	27,866,962,387.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	26,617,708,722.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	26,617,708,722.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,285,000.00	-
131003	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	10,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	12,770,978.00	125,332,065.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,770,978.00	125,332,065.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,174,871,500.00	1,123,921,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,174,871,500.00	1,099,995,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	23,926,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	355,559,172,657.33	541,350,938,707.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,559,172,657.33	541,350,938,707.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,073,55,908.95	1,126,566,477.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,584,867.00	839,137,702.14
210101	Үндсэн цалин	542,234,944.00	570,596,579.91
210102	Нэмэгдэл	146,124,930.00	109,544,957.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,705,000.00	96,746,743.36
210104	Урамшуулал	11,519,993.00	62,249,421.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,375,582.92	111,150,072.28
210201	Тэтгэврийн даатгал	73,601,265.82	77,103,374.79
210202	Тэтгэмжийн даатгал	8,190,919.88	9,207,559.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,552,735.91	7,366,008.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,638,183.98	1,785,460.48
210205	Эрүүл мэндийн даатгал	16,392,477.33	15,687,668.68

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,175,900.00	32,634,428.67
210301	Гэрэл, цахилгаан	13,034,100.00	8,889,588.00
210302	Түлш, халаалт	24,760,800.00	20,054,911.67
210303	Цэвэр, бохир ус	3,381,000.00	3,689,929.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,609,768.99	24,195,903.36
210401	Бичиг хэрэг	9,016,150.00	10,639,864.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	3,355,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,446,529.99	4,420,825.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,700.00	1,110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,928,389.00	4,669,414.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	20,643,500.00
210604	Урсгал засвар	-	20,643,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,563,566.00	26,791,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,938,227.00	5,797,451.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,900,000.00	5,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	292,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	201,590.00	684,202.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,009,710.00	7,929,890.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	11,232,055.00	6,127,705.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,246,224.04	72,013,539.11
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,285,000.00	2,561,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,961,224.04	69,452,539.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	354,485,616,748.38	540,224,372,230.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,046,935,616.00	173,841,901,812.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	137,914,725,822.00	173,804,359,990.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,340,000.00	14,281,022.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	119,869,794.00	23,261,200.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	216,438,681,132.38	366,382,470,418.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	216,438,681,132.38	366,382,470,418.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,646,287,949.78	(47,758,731,812.37)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	427,990.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	427,990.00	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	23,646,715,939.78	(47,758,731,812.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>357,548,366,865.48</u>	<u>540,643,040,800.39</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	350,795,122,562.96	456,859,080,074.41
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	350,795,122,562.96	456,859,080,074.41
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	246,151,290,821.99	306,083,443,893.70
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	19,568,785,930.07	33,004,230,346.63
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	23,990,585,397.01	37,876,502,494.30
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,922,092,098.17	6,694,352,547.43
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	57,162,368,315.72	73,200,550,792.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	487,166,263.30	439,629,825.98
120	Нийтлэг татварын бус орлого	487,166,263.30	439,629,825.98
120002	Хүүгийн орлого	18,803,461.39	2,075,273.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,362,801.91	437,554,552.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	464,830,801.91	437,148,552.52
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,532,000.00	406,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,266,078,039.22	83,344,330,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,080,921,539.22	82,170,421,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,080,921,539.22	82,170,421,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,285,000.00	-
131003	ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	10,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	-	49,987,700.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	49,987,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,174,871,500.00	1,123,921,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,174,871,500.00	1,099,995,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	23,926,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>356,098,356,336.78</u>	<u>541,919,726,773.12</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,098,356,336.78	541,919,726,773.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,011,563,220.81	1,056,917,922.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	759,611,943.00	841,110,626.14
210101	Үндсэн цалин	540,262,020.00	572,569,503.91
210102	Нэмэгдэл	146,124,930.00	109,544,957.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,705,000.00	96,746,743.36
210104	Урамшуулал	11,519,993.00	62,249,421.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,232,499.82	110,341,028.38
210201	Тэтгэврийн даатгал	73,502,266.62	76,294,330.89
210202	Тэтгэмжийн даатгал	8,179,902.49	9,207,559.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,543,921.99	7,366,008.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,635,980.50	1785,460.48
210205	Эрүүл мэндийн даатгал	16,370,428.22	15,687,668.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,175,900.00	32,634,428.67
210301	Гэрэл, цахилгаан	13,034,100.00	8,889,588.00

210302	Түлш, халаалт	24,760,800.00	20,054,911.67
210303	Цэвэр, бохир ус	3,381,000.00	3,689,929.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,157,931.99	25,457,212.36
210401	Бичиг хэрэг	12,492,702.00	11,248,630.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	3,355,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,446,529.99	4,420,825.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	218,700.00	1,110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,000,000.00	5,321,957.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,050,000.00	23,430,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,050,000.00	2,786,500.00
210604	Урсгал засвар	-	20,643,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,049,946.00	21,383,627.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,938,227.00	5,797,451.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,180,000.00	6,620,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	292,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	81,984.00	59,984.00
210807	Газрын төлбөр	201,590.00	684,202.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,009,710.00	7,929,890.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,438,435.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,285,000.00	2,561,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,285,000.00	2,561,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	355,086,793,115.97	540,862,808,850.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,648,210,458.59	174,480,338,432.22
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	138,394,509,229.39	173,886,632,852.01
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,340,000.00	14,281,022.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	121,491,435.20	556,163,358.21
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	119,869,794.00	23,261,200.00
2135	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	216,438,582,657.38	366,382,470,418.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	216,438,582,657.38	366,382,470,418.35
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,450,010,528.70</u>	<u>(1,276,685,972.73)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	≡
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,062,820,556.15	16,512,831,084.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,512,831,084.85	15,236,145,112.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	123,694,442,135.25	124,324,411,835.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(177,826,929.66)	(177,826,929.66)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	123,516,615,205.59	123,516,615,205.59
Тайлант үеийн үр дүн	-	-	23,646,715,939.78	23,646,715,939.78
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	147,163,331,145.37	147,793,300,846.01
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	147,163,331,145.37	147,793,300,846.01
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(229,145,740.40)	(229,145,740.40)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	146,934,185,404.97	147,564,155,105.61
Тайлант үеийн үр дүн	-	-	(47,758,731,812.37)	(47,758,731,812.37)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	99,175,453,592.60	99,805,423,293.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	177,096,865,900.00	174,977,610,196.56	(2,119,255,703.44)	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	177,096,865,900.00	174,977,610,196.56	(2,119,255,703.44)	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,074,011,100.00	1,056,917,922.55	(17,093,177.45)	95.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	842,452,500.00	841,110,626.14	(1,341,873.86)	99.8
210101	Үндсэн цалин	572,847,300.00	572,569,503.91	(277,796.09)	99.9
210102	Нэмэгдэл	103,861,900.00	109,544,957.48	5,683,057.48	105.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	102,430,100.00	96,746,743.36	(5,683,356.64)	94.5
210104	Урамшуулал	63,313,200.00	62,249,421.39	(1,063,778.61)	98.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,710,400.00	110,341,028.38	(369,371.62)	99.7
210201	Тэтгэврийн даатгал	76,633,700.00	76,294,330.89	(339,369.11)	99.6
210202	Тэтгэмжийн даатгал	9,142,700.00	9,207,559.83	64,859.83	100.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,314,700.00	7,366,008.50	51,308.50	100.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,820,000.00	1,785,460.48	(34,539.52)	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	15,799,300.00	15,687,668.68	(111,631.320)	99.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,279,700.00	32,634,428.67	(5,645,271.33)	85.3
210301	Гэрэл, цахилгаан	10,351,300.00	8,889,588.00	(1,461,712.00)	85.9
210302	Түлш, халаалт	24,194,000.00	20,054,911.67	(4,139,088.33)	82.9
210303	Цэвэр, бохир ус	3,734,400.00	3,689,929.00	(44,471.00)	98.8
2104	Хангамж, бараа материалын зардал	26,121,500.00	25,457,212.36	(664,287.64)	97.5
210401	Бичиг хэрэг	11,250,000.00	11,248,630.00	(1,370.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,734,400.00	3,355,800.00	(378,600.00)	89.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,577,100.00	4,420,825.36	(156,274.64)	96.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	1,110,000.00	(125,000.00)	89.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,325,000.00	5,321,957.00	(3,043.00)	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,561,000.00	23,430,000.00	(131,000.00)	99.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,811,000.00	2,786,500.00	(24,500.00)	99.1
210604	Урсгал засвар	20,750,000.00	20,643,500.00	(106,500.00)	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,036,000.00	21,383,627.00	(8,652,373.00)	71.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,858,500.00	5,797,451.00	(1,061,049.00)	84.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,620,000.00	6,620,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	292,100.00	(207,900.00)	58.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	59,984.00	(140,016.00)	30.0
210807	Газрын төлбөр	700,000.00	684,202.00	(15,798.00)	97.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,157,500.00	7,929,890.00	(7,227,610.00)	52.3

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,850,000.00	2,561,000.00	(289,000.00)	89.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,561,000.00	(289,000.00)	89.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	176,022,854,800.00	173,920,692,274.01	(2,102,162,525.99)	98.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	176,022,854,800.00	173,920,692,274.01	(2,102,162,525.99)	98.8
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	175,957,929,200.00	173,886,632,852.01	(2,071,296,347.99)	98.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,876,000.00	10,798,222.00	(1,077,778.00)	90.9
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,049,600.00	23,261,200.00	(29,788,400.00)	43.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	177,096,865,900.00	466,136,939,793.04	289,040,073,893.04	263.2
	Улсын төсвөөс санхүүжих	82,170,421,600.00	82,170,421,600.00	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	94,926,444,300.00	383,684,214,276.32	288,757,769,976.32	404.2
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	94,902,518,100.00	383,660,288,076.32	288,757,769,976.32	404.2
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,926,200.00	23,926,200.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	282,303,916.72	282,303,916.72	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	281,897,916.72	281,897,916.72	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	406,000.00	406,000.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,512,831,084.85	16,512,831,084.85	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,236,145,112.12	15,236,145,112.12	100.0
	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		(292,436,015,569.21)	(292,436,015,569.21)	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61	53	(8)	86.9
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	52	45	(7)	86.5
620003	Үйлчлэх ажилтан	8	7	(1)	87.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2022 оны үйл ажиллагааны зорилгоо *“Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ”*. Хэтийн зорилгоо *“Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болно.”* гэж тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого зарлагын гүйцэтгэлийг хангах;
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Хуульд заасан бусад үйл ажиллагаа;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн 408 тоот тогтоол “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2022 оны хувь хэмжээг тогтоох тухай” -оор Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4 хувь, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь байхаар тогтоосон.
- НДЕГ-ын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 5/2291 тоот албан бичгээр Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргахад анхаарч, санхүүгийн бүртгэлд тусгах арга аргачлал, чиглэл заавар өгч ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөтэй гэж үзлээ.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, 267 ажил олгогч байгууллага, 19,929 даатгуулагч болон шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан өндөр насны 1,567, тахир дутуугийн 628, тэжээгчээ алдсаны 124, цэргийн тэтгэвэр авагч 79, нийт 2,398 даатгуулагчийн баримт материалд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар 438,672.6 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 348,431.6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулан ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудитын газар нь 2022 онд Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэсэн байна.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,946,659.8 мянган төгрөгөөр буюу 31.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,512,831.1	15,236,145.1	(1,276,686.0)
Авлага	130,313,636.3	84,639,850.5	(45,673,785.8)
Бараа материал	38,282.3	38,669.2	386.9
Үндсэн хөрөнгө	2,242,306.4	2,245,731.4	3,425.1
Нийт хөрөнгө	149,107,056.0	102,160,396.2	(46,946,659.8)
Өр төлбөр	1,313,755.2	2,354,972.9	1,041,217.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	147,793,300.8	99,805,423.3	(47,987,877.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	149,107,056.0	102,160,396.2	(46,946,659.8)

Дээрх хүснэгтээс харахад материаллаг өөрчлөлт гарсан авлага, засгийн газрын оролцоо данснууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,236,145.1 мянган төгрөг болж 1,276,686.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж авах иргэний тоо нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 84,639,850.5 мянган төгрөг болсон байна. Энэ нь татаас санхүүжилтийн авлага 55,562,612.7 мянган төгрөгөөр буурч, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 9,908,675.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, байгууллагаас авах авлага 11,289.9 мянган төгрөгөөр буурснаас нийт 45,673,785.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 9,908,675.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засгийн байдал хүндэрч ажил олгогч байгууллага цаг

хугацаандаа нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулаагүйгээс болсон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 3.2 хувь буюу 1,110,626.0 мянган төгрөг нь шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн ч эргэн төлөлт хийгдээгүй байна. Мөн энэ байдлаар 365 хоногоос дээш насжилттай авлагын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Иймд байгууллагын хувьд авлага барагдуулах талаар арга хэмжээ авахыг анхааруулж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38,669.2 мянган төгрөг болж 386.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 11,248.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 5,321.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,786.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 2,466.8 мянган төгрөгийн хангамжийн материал, маягт худалдан авч, 21,436.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байсан болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,245,731.4 мянган төгрөг болж 3,425.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДЕГ-ын даргын 2022 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн А/69 тоот тушаалаар 30,854.9 мянган төгрөгийн 3 төрлийн 48 ширхэг тоног төхөөрөмж, 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар 41,922.7 мянган төгрөгийн 9 төрлийн тоног төхөөрөмж бүхий хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч тус тус бэлтгэсэн, ТӨБЗГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 695 тоот тушаалаар 48,215.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглах боломжгүй, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн гэж үзэж актлах шийдвэрийн дагуу данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт гараагүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,354,972.9 мянган төгрөг болж 1,041,217.8 мянган төгрөгөөр өссөн нь сайн дурын даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт, урьдчилж орсон орлого 1,011,743.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 99,805,423.3 мянган төгрөг болж 47,987,877.6 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын хэлтэс, сангийн тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 114,386,746.3 мянган төгрөгөөр буюу 30.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого байна. Энэ нь тайлант онд 514 аж ахуйн нэгж, 11 төсөвт байгууллага, 3,615 хувиараа хөдөлмөр эрхлэгч, шинээр 1,369 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаж нийт даатгуулагчийн тоо нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 185,791,766.1 мянган төгрөгөөр буюу 52.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж, урсгал болон төвлөрүүлэх шилжүүлгүүд байна. Энэ нь улсын төсвөөс олгосон санхүүжилт, нийгмийн даатгалын шимтгэлийн шилжүүлгийн дүн өссөн зэргээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 229,145.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны тэтгэвэр, тэтгэмжийн илүү олгосон зардлыг НДЕГ-ын байцагчийн актаар буцаасан, тайлант үеийн үр дүн 47,758,731.8 мянган төгрөгийн алдагдалтай гарснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 214,285,235.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,188,369.2 мянган төгрөгөөр бууруулж, 177,096,865.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өнгөрсөн онд Ковид-19 цар тахлын хамрах хүрээ буурч байгаатай холбогдуулан эдийн засгийн сэргэлт үүсэж нийгмийн даатгалын шимтгэл төлөлт өсөх магадлалтай гэж үзэн санхүүжилтийн эх үүсвэрийг бууруулан баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 зорилт, 8 арга хэмжээний хүрээнд 59 хөтөлбөрийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр 177,096,865.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 176.022.854.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангийн зардалд, 1,074,011.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 465,854,635.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 282,303.9 мянган төгрөг, нийт 466,136,939.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, тэтгэвэр, тэтгэмжийн урсгал зардал болон үйл ажиллагаанд 173,700,924.2 мянган төгрөгийг зарцуулж 292,436,015.6 мянган төгрөгийг НДЕГ-т буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 174,977,610.2 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,711.2 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 5,645.3 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 664.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт зардлыг 8,652.3 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 131.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 2,102,162.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Чингэлтэй Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь 2022 онд нэмэлт төсөв, санхүүжилт хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ий ахлах аудитор Ж.Эрдэнэбилэг, аудитор Д.Сугар, аудиторын туслах Ө.Дэлгэрмаа, Б.Энхчимэг нар гүйцэтгэж, хяналтыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Д.Мэндбаяр, захирал Д.Энхбаатар, НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн байдлын тайланг, суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн 149,107,056.0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 2,982,141.1 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 2,087,498.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд батлагдсан орон тооноос 8-аар бага албан хаагчидтайгаар ажилласан байна. Тайлант хугацаанд 1,711.2 мянган төгрөгийн цалин, шимтгэлийн зардал, 265.6 мянган төгрөгийн шатахууны зардал, 2,869.4 мянган төгрөгийн шуудан холбоо, интернетийн зардлын хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 22 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сан нь тайлант хугацаанд нийт 314 мэдээлэл байршуулахаас 311 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод, хугацаанд нь байршуулж, 104,282.2 мянган төгрөгийн 3 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2 "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," 6.4.8 "...,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", СТОУС-ын 1 "Тайлангийн толилуулга" ... үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг стандартад заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг..." заалтуудтай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 218,577.6 сая төгрөгийн зөрчил арилгах 3 албан шаардлагыг 100.0 хувь, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	216,783,100.0	3	216,783,100.0	100.0%
Зөвлөмж	1	1,794,500.0	1	-	70.0%
Нийт дүн	4	218,577,600.0	4	216,783,100.0	85.5%

Өмнөх оны аудитаар тогтоосон 1 зөвлөмж нь өндөр насжилттай авлага байсан ба авлага барагдуулах ажил хангалтгүй хийгдсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Авлага өмнөх оноос 9,908,675.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 3.2 хувь буюу 1,110,626.0 мянган төгрөгийн авлага шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн ч эргэн төлөлт хангалтгүй хийгдсэн тул авлага цуглуулах ажиллагаа идэвхжүүлсэн, арга хэмжээ авсан эсэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 104,282.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснийг алдаа зөрчлийг арилгах 3 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Авлагын үлдэгдэл НДЕГ-аас баталсан ажлын төлөвлөгөөнд “нийт төлбөртэй үйлчилгээний шимтгэлийн орлогын 10.0 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх оноос 9,908,675.5 мянган төгрөгөөр өссөн. НДШ-ий авлагын 3.2 хувь буюу 1,110,626.0 мянган төгрөг нь Шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн ч эргэн төлөлт хангалтгүй, арга хэмжээ авагдаагүй байна. Авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллаагүйгээс авлагын өсөлт жил бүр өсөн нэмэгдэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “*өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдээгдлийг тооцсон байх*” заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “*дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах*”, 20.2.6 “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдээгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулах ажлыг зохион байгуулж, арга хэмжээ авч ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. **Илрүүлэлт:** Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, анхны өртгөө нөхсөн нийт 6,350.0 мянган төгрөгийн 3 нэрийн, 8 ширхэг үндсэн хөрөнгө байна. Тооллогын бүртгэлээр тус хөрөнгүүдийн чанар байдлыг тодорхойлоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 “*...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;*” УСНББОУС-17 14 дүгээр зүйл Хүлээн зөвшөөрөлт “*Үндсэн хөрөнгийн өртгийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө ...б.Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхыг найдвартай хэмжиж чадах...*”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 “*Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ*” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг бодит үнэ цэнээр шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2022 оны санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа 3 нэрийн, 8 ширхэг 6,350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	1	-					1	-
НДШ-ийн авлага өмнөх оноос 9,908,675.5 мянган төгрөгөөр өссөн, тайлант хугацаанд авлага барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна.	1	-					1	-
Дүн	2	-					2	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан	1	104,282.2					1	104,282.2
Дүн	1	104,282.2					1	104,282.2
Нийт дүн	3	104,282.2					3	104,282.2

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

“ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал

Аудитор



Д.Энхбаатар

Ж.Эрдэнэбилэг